

# Талантын зүйрлэл

-The Parable of the Talents-



62Page

**Тайлбарлагч** Дээр үед нэгэн хүн алс холын нутаг руу аялалаар явах болдог.

Тэр явахаасаа өмнө өөртөө байсан хөрөнгөнөөсөө гурван зарцдаа хувааж өгөнгөө ингэж захидаг.

**Эзэн** Би өөртөө байгаагаа хувааж өгөх учир намайг буцаж иртэл худалдаа наймаа хийгээд үз.

**Тайлбарлагч** Эзэн ингэж хэлээд эхний зарцдаа таван алтан талант, хоёр дахь зарцдаа хоёр алтан талант, гурав дахь зарцдаа нэг алтан талант тус тус хувааж өгөв.

**Эзэн** За, та нарын авьяасын дагуу өгсөн учир хичээнгүй сайн хийгээд үзээрэй.

**Тайлбарлагч** Тэгээд эзэн нь холын хол замд гарлаа.

.....

**Тайлбарлагч** Эзэн нь явсаны дараагаар эхний зарц болон хоёр дахь зарц тэр даруй наймаа хийж эхлэв. Даалгасан ажлыг нь сайн хийвэл эзэн маань баярлах болно гэсэн сэтгэлээр хийцгээв.

Үзэгдэл-4

Эхний зарц нь эзнийхээ даалгасан таван талантаар тариа будаан наймаа хийв.

Хоёр дахь зарц нь эзнийхээ даалгасан хоёр талантаар наймаа хийв. Ингээд нэг, хоёр, гурав гэсээр өдөр хоногууд өнгөрч, нэг сар, хоёр сар өнгөрч хичээнгүй ажилласан ажлын дүн нь гарав.

Эхний зарц нь таван талантаа арав болгон өсгөж, хоёр дахь зарц нь хоёр талантаа дөрөв болгон өсгөв.

Харин гурав дахь зарц нь юу хийсэн юм бол?

.....

**Тайлбарлагч** Хэдэн сар өнгөрсний эцэст эзэн нь холын аянаасаа буцаж ирэв.

Гурван зарц нь эзэн дээрээ очиж тэр хугацаанд хийсэн ажилаа тайлагнав.

**Эзэн** Сайн байна, итгэмжит сайн зарц минь. Чи жижиг ажилд ч итгэмжтэй хандсан тул чамд цааш нь ихийг хариуцуулж өгөх болно. Эзнийхээ баяр баясгалаанд ор

**Тайлбарлагч** Эзэн нь хоёр дахь зарцаа мөн адил магтав.

**Эзэн** Сайн байна, итгэмжит сайн боол минь. Чи бага зүйлд ч итгэмжтэй хандсан тул чамд цаашид ихийг хариуцуулах болно.



63Page



64Page



65Page

**Тайлбарлагч** Хоёр зарц нь хичээнгүй сайн хөдөлмөрлөсөнд эзэн нь ихэд баярлажээ. Тэгээд цашид ч олон ажил даатгах болохоо амлав.

.....

**Тайлбарлагч** Хамгийн сүүлд гурав дахь зарц нь ажилаа тайлагнав.

**Зарц3** Эзэнтэн минь, би таныг үр суулгаагүй газраас хадаж авдаг, юу ч цацаагүй газраас түүж авдаг хатуу хүн гэдгийг мэднэ. Би айсан тул явж таны талантыг газарт нуучихсан. Хар, таны юм энэ байна.

**Тайлбарлагч** Үүнийг сонссон эзэн маш ихээр уурлав.

**Эзэн** Юу юу гэнээ чи, муу хар залхуу боол, чи намайг үр суулгаагүй газраас хадаж авдаг, юу ч цацаагүй газраас түүж авдгийг мэддэг гэнээ? Тэгвэл чи мөнгө хүүлэгчид мөнгөө хадгалуулах байсан юм. Тэгсэн бол буцаж ирээд өөрийнхөө мөнгийг хүүтэй авах байсан юм. Түүнээс нэг талантыг авч арван таланттай хүнд өг. Энэ зохисгүй боолыг харанхуйд хөөж гарга.

.....



66Page

**Тайлбарлагч** Эцэст нь хамгийн сайнаараа хичээнгүйлэн ажилласан хоёр зарц нь эзнийхээ баяр баясгаланд хамт орж, харин юу ч хийгээгүй залхуу боол гунгинтайгаар хөөгдөн гаржээ.